



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Сонгино сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/157/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.21 № 102
танай -нм № -т

СОНГИНО СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б. БАЯРСАЙХАН-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сонгино сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сонгино сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус сумын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ахмад багш нар болон үр хүүхдүүдээс 7,502.8 мянган төгрөгийн, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 6,016.8 мянган төгрөгийн, аймгийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалтаар 14,185.6 мянган төгрөгийн, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2,100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл хандивласныг бүртгэлд тусгасан байна. Мөн байгууллагын 3140 м.кв газрыг 15 жилийн хугацаатай эзэмшихээр гэрчилгээжүүлэн 6,280.0 мянган төгрөгөөр үнэлж бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Сонгино сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Сонгино сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 61 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 98 хувьтай үнэлэгдсэн байна.

D/disk/Албан бичиг/Дүгнэлт

8.1.5 2025

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	96,738,247.21	165,241,856.85
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	41,848,106.29	107,849,085.93
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	41,848,106.29	107,849,085.93
3121	Төгрөг	41,848,106.29	107,849,085.93
31211	Төрийн сангийн харилцах	41,848,106.29	107,849,085.93
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	54,890,140.92	57,392,770.92
351	Түүхий эд материал	1,881,440.00	2,107,940.00
35110	Тусгай зориулалттай материал	786,000.00	1,012,500.00
35130	Эм боох материал	1,095,440.00	1,095,440.00
354	Хангамжийн материал	53,008,700.92	55,284,830.92
35410	Бичиг хэргийн материал	66,500.00	60,700.00
35420	Аж ахуйн материал	2,061,950.00	2,406,050.00
35450	Барилгын засварын материал	2,450,000.00	700,000.00
35460	Хүнсний материал	955,520.00	2,683,550.00
35470	Бусад хангамжийн материал	47,474,730.92	49,434,530.92
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	749,917,024.10	737,713,498.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	749,917,024.10	737,713,498.54
392	Биет хөрөнгө	743,465,149.10	731,433,498.54
39201	Барилга, байгууламж	600,028,212.00	600,028,212.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(41,512,197.60)	(50,340,724.08)
39205	Машин, тоног төхөөрөмж	45,114,066.13	67,916,461.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,226,156.67)	(19,838,426.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,689,554.20	29,692,354.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,726,827.52)	(14,714,554.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	154,139,291.00	154,139,291.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(18,228,322.44)	(36,636,644.88)
39217	Номын фонд	1,187,530.00	1,187,530.00
393	Биет бус хөрөнгө	6,451,875.00	6,280,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хасагдуулга	(1,478,125.00)	(1,650,000.00)

39303	Бусад биет бус хөрөнгө	6,280,000.00	6,280,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	846,655,271.31	902,955,355.39
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	846,655,271.31	902,955,355.39
51	Засгийн газрын хувь оролцоо	846,655,271.31	902,955,355.39
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	34,585,917.69	34,585,917.69
51101	Өмч: -Төрийн өмч	34,585,917.69	34,585,917.69
512	Хуримтлагдсан үр дүн	812,069,353.62	868,369,437.70
51210	Өмнөх үеийн үр дүн	812,069,353.62	812,069,353.62
51220	Тайлант үеийн үр дүн	-	56,300,084.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ /ӨМЧИЙН ДҮН/	846,655,271.31	902,955,355.39

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	452,926,092.93	621,326,495.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,165,792.93	29,910,195.00
120	Нийтлэг татварын бус орлого	79,165,792.93	29,910,195.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	79,165,792.93	29,910,195.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	185,000.00	105,000.00
1200045	Үнэ толборгүй хүлээн авсан орлого	78,980,792.93	29,805,195.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	373,760,300.00	591,416,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	335,404,900.00	546,922,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	335,404,900.00	546,922,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,355,400.00	44,494,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,355,400.00	44,494,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	399,404,893.05	565,026,410.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	399,404,893.05	565,026,410.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,666,455.33	563,585,869.27
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	250,069,411.00	371,491,274.00
210101	Цалин	172,420,724.00	234,928,251.00
210102	Нэмэгдэл цалин	70,145,318.00	123,622,453.00
210104	Урамшуулал	7,503,369.00	12,940,570.00
2102	Ажил олгогчөөс нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,205,908.95	46,400,634.36
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	21,255,887.26	31,723,657.36

210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,500,691.44	3,606,845.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,000,555.36	1,803,423.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	482,733.70	1,797,275.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,966,041.19	7,469,434.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,616,962.28	41,100,008.35
210301	Гэрэл цахилгааны зардал	3,963,882.28	4,431,408.35
210302	Түлш, халаатгын зардал	31,078,080.00	36,518,600.00
210303	Цэвэр, бохир усны зардал	575,000.00	150,000.00
2104	Хашгамж, бараа материалын зардал	5,072,042.00	5,403,652.00
210401	Бичиг хэргийн материал	557,000.00	245,400.00
210402	Тээвэр, шатахууны зардал	2,655,684.00	3,023,852.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,315,850.00	2,134,400.00
210408	Бараа материал актасны зардал	543,508.00	-
2105	Нормативт зардал	37,970,870.00	44,974,530.00
210501	Эм	108,970.00	-
210502	Хоол	37,861,900.00	44,974,530.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	250,000.00	3,703,750.00
210604	Урсгал засвар	250,000.00	3,703,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	666,600.00	296,800.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	666,600.00	296,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,814,661.10	50,215,220.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,646,800.00	3,413,700.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн даллагын зардал	1,971,000.00	4,792,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,196,861.10	42,008,720.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	738,437.72	1,440,541.65
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	738,437.72	1,440,541.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	738,437.72	1,440,541.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	53,521,199.88	56,300,084.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	99,587.66	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	99,587.66	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI-IV-V)	(99,587.66)	-
5	НИЙТ ҮР ДҮН (VII-III+VI)	53,421,612.22	56,300,084.08

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	34,585,917.69		812,069,353.62	846,655,271.31
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	34,585,917.69		812,069,353.62	846,655,271.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,585,917.69		812,069,353.62	846,655,271.31
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-		56,300,084.08	56,300,084.08
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	34,585,917.69		868,369,437.70	902,955,355.39

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	373,945,300.00	591,521,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	185,000.00	105,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	185,000.00	105,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	185,000.00	105,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	185,000.00	105,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	373,760,300.00	591,416,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	335,404,900.00	546,922,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	335,404,900.00	546,922,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,355,400.00	44,494,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,355,400.00	44,494,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	367,978,163.95	525,520,320.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	367,978,163.95	525,520,320.36
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	367,239,726.23	524,079,778.71
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	250,069,411.00	371,491,274.00
210101	Үндсэн цалин	172,420,724.00	234,928,251.00
210102	Нэмэгдэл	70,145,318.00	123,622,453.00
210104	Үр дүнгийн урамшуулал	7,503,369.00	12,940,570.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	31,205,908.95	46,400,634.36
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	21,255,887.26	31,723,657.36

210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,500,691.44	3,606,845.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,000,555.36	1,803,423.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	482,733.70	1,797,275.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,966,041.19	7,469,434.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	35,616,962.28	41,100,008.35
210301	Гэрэл цахилгааны зардал	3,963,882.28	4,431,408.35
210302	Түлш, халаалтын зардал	31,078,080.00	36,518,600.00
210303	Цэвэр, бохир усны зардал	575,000.00	150,000.00
2105	Нормативт зардал	35,472,460.00	46,702,560.00
210502	Хоол, хүнс	35,472,460.00	46,702,560.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,953,750.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,953,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	666,600.00	296,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	666,600.00	296,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,208,384.00	16,134,752.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,208,484.00	11,115,452.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	1,999,900.00	5,019,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	738,437.72	1,440,541.65
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	738,437.72	1,440,541.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	738,437.72	1,440,541.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Ш)=(Н)-(II)	5,967,136.05	66,000,979.64
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	5,967,136.05	66,000,979.64
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	35,880,970.24	41,848,106.29
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	41,848,106.29	107,849,085.93

Төсвийн гүйцэтгэлийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31 мянган төгрөгөөр

Данс	Тусуулал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	41,848,106.29	(41,848,106.29)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	630,304,000.00	525,520,320.36	104,783,679.64	83.38
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	630,304,000.00	525,520,320.36	104,783,679.64	83.38
210	Бараа, үйлчилгээний зардал	630,304,000.00	524,079,778.71	106,224,221.29	83.15
2101	Цалин хөнгө болон нэмэгдэл урамшил	455,541,400.00	371,491,274.00	84,050,126.00	81.55
210101	Үндсэн цалин	309,135,400.00	234,928,251.00	74,207,149.00	76.00
210102	Нэмэгдэл	141,694,700.00	123,622,453.00	18,072,247.00	87.25
210104	Урамшуулал	4,711,300.00	12,940,570.00	(8,229,270.00)	274.67
2102	Ажил олгогчоос цийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,395,800.00	46,400,634.36	6,995,165.64	86.90
210201	Тэтгэврийн даатгал	36,310,100.00	31,723,657.36	4,586,442.64	87.37
210202	Тэтгэмжийн даатгал	4,270,700.00	3,606,845.00	663,855.00	84.46
210203	ҮОМШӨ ний даатгал	2,135,800.00	1,803,423.00	332,377.00	84.44
210204	Ажилгүйдлийн даатгал	2,135,800.00	1,797,275.00	338,525.00	84.15
210205	Эрүүл мэндийн даатгал	8,543,400.00	7,469,434.00	1,073,966.00	87.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,494,300.00	41,100,008.35	1,394,291.65	96.72
210301	Гэрэл цахилгаан	5,075,700.00	4,431,408.35	644,291.65	87.31
210302	Түлш, халаалт	36,518,600.00	36,518,600.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	900,000.00	150,000.00	750,000.00	16.67
2105	Нормативт зардал	56,076,100.00	46,702,560.00	9,373,540.00	83.28
210502	Хоол, хүнс	56,076,100.00	46,702,560.00	9,373,540.00	83.28
2106	Эд хогшил худалдан авах	2,000,000.00	1,953,750.00	46,250.00	97.69
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,953,750.00	46,250.00	97.69
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,757,400.00	296,800.00	1,460,600.00	16.89
210806	Мэдээллийн технологийн зардал	1,757,400.00	296,800.00	1,460,600.00	16.89
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	19,039,000.00	16,134,752.00	2,904,248.00	84.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,019,000.00	11,115,452.00	2,903,548.00	79.29
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,020,000.00	5,019,300.00	700.00	99.99
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,440,541.65	(1,440,541.65)	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,440,541.65	(1,440,541.65)	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,440,541.65	(1,440,541.65)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	630,304,000.00	591,521,300.00	38,782,700.00	93.85
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	546,922,000.00	546,922,000.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	546,922,000.00	546,922,000.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	44,494,300.00	44,494,300.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	44,494,300.00	44,494,300.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	38,887,700.00	105,000.00	38,782,700.00	0.27

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	105,000.00	-	100.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	38,782,700.00	-	38,782,700.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	41,848,106.29	(41,848,106.29)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	107,849,085.93	(107,849,085.93)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	15.00	15.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	125.00	125.00	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	44,494,300.00	44,494,300.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	44,494,300.00	44,494,300.00	-	100.00
210	Бараа, үйлчилгээний зардал	44,494,300.00	43,053,758.35	1,440,541.65	96.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,494,300.00	41,100,008.35	1,394,291.65	96.72
21030	1 Гэрэл цахилгаан	5,075,700.00	4,431,408.35	644,291.65	87.31
21030	2 Түлш, халаалт	36,518,600.00	36,518,600.00	-	100.00
21030	3 Цэвэр, бохир ус	900,000.00	150,000.00	750,000.00	16.67
2106	Эд хогшил худалдан авах	2,000,000.00	1,953,750.00	46,250.00	97.69
21060	4 Урсгал засвар	2,000,000.00	1,953,750.00	46,250.00	97.69
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,440,541.65	(1,440,541.65)	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,440,541.65	(1,440,541.65)	-
21340	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,440,541.65	(1,440,541.65)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	44,494,300.00	44,494,300.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	44,494,300.00	44,494,300.00	-	100.00
13200	1 Орон нутгийн төсвөөс	44,494,300.00	44,494,300.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Сонгино сумын хүүхдийн цэцэрлэгийн чиглэл:

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

Завхан аймгийн Сонгино сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго:

Завхан аймгийн Сонгино сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 61 арга хэмжээ төлөвлөснөөс 98.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завхан аймгийн Сонгино сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
10. Хөдөлмөрийн тухай хууль
11. Шилэн дансны тухай хууль
12. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай”, “цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх” зэрэг Засгийн газрын тогтоолуудад өөрчлөлт орсон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналт тавин ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Сонгино сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Сонгино сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 56.30061 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар өссөн дансны үлдэгдэл өмнөх оноос өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	41,848.1	107,849.1	66,001.0
Авлага	0	0	0
Бараа материал	54,890.1	57,392.8	2,502.7
Үндсэн хөрөнгө	749,917.0	737,713.5	-12,203.5
Нийт хөрөнгө	846,655.3	902,955.4	56,300.1
Өр төлбөрийн дүн	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	846,655.3	902,955.4	56,300.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	846,655.3	902,955.4	56,300.1

Санхүүгийн тайлангийн төдруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 66,001.0 мянган төгрөгөөр, бараа материал 2,502.7 мянган төгрөгөөр өссөн бол үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 12,203.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Тус цэцэрлэг нь оны эхэнд 54,890.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр 61,377.4 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч 58,874.7 мянган төгрөгийн зарцуулалт хийснээр оны эцэст 57,392.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Үндсэн хөрөнгийн хувьд 29,805.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл хандив тусламжаар хүлээн авч бүртгэлд тусгажээ. 42,008.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/-д тайлант онд өөрчлөлт ороогүй болно.

Тайлант оны эцэст өглөг, авлага үүсгээгүй нь төсвийг зөв зохистой удирдан зарцуулж чадсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай” 82, 128 дугаар тогтоолуудын дагуу ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл нэмэгдэж, төсвийг тодотгосноор тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 546,922.0 мянган төгрөг, зардлыг 546,922.0 мянган төгрөг байхаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн, батлуулж ажилласан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 546,922.0 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 44,494.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагаанаас 105.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, 524,079.8 мянган төгрөгийг зарцуулан ажиллажээ. Төсвийн нийт зарцуулалт 88.6 хувьтай байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 84,050.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 6,995.2 мянган төгрөгөөр, хоол, хүнсний зардлыг 9,373.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 1,460.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,904.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр агаа хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөг өө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71801	Сургуулийн өмнөх боловсрол	585,809.7	481,026.0	104,783.7	82.11
80233	Хүүхэд хамгааллын зардал	792.5	790.0	2.5	99.99
81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	1,124.9	1,124.9	0	100
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал	56,076.1	46,702.6	9,373.5	83
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,959.8	1,959.8	0	100
81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардал	1,128.0	359.2	768.8	32
81833	Явуулын багшийн үйлчилгээ	7,128.0	2,977.1	2,587.5	35
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	513,605.9	423,756.8	89,849.1	82.5
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	3738.5	3,102.4	636.1	82.98
81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	255.0	252.5	2.5	99.99
Дүн		585,809.7	481,026.0	104,783.7	82.11
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
81901	Тогтмол зардал	44,494.3	43,053.7	1,440.5	96.76
Нийт дүн		630,304.0	524,079.7	106,224.3	83.15

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орон нутгийн төсвөөс 44,494.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой зардалд 41,100.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,953.8 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 1,440.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Тайлант онд хүнсний болон аж ахуйн материалуудад худалдан авалт зарласан байна.

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Мөнхцавдангийн үндарга ХХК тендерт шалгарсан /харьцуулалтын арга/	Хоол хүнс, бараа үйлчилгээ	75,115.1	62,837.2
2	АУЭХС шууд гэрээ	Цахилгаан эрчим хүчээр хангах	5,075.7	4,431.4
3	Хурд хүч чадал ХХК шууд гэрээ	Дулаанаар хангах	36,518.6	36,518.6
ДҮН			116,709.4	103,787.2

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Завхан аймгийн Сонгино сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Сонгино сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 367,978.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцож, 5,519.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувь буюу 4,139.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Сонгино сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан тул акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Хүүхдийн хоолны нормативыг мөрдөж, ажиллах

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

5.1 Төлбөрийн акт: тогтоогоогүй

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж: өгөгдөөгүй

Аудитын явцад материаллаг шинж чанартай алдаа илрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган рөөвөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж		
	Тоо	Дүн		Тоо	Дүн	Залруулсан	Залруу-лаагүй		Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт	Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
	Тоо	Дүн		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД
О.Х.БОЛДБААТАР
Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-20

БОЛОВСРУУЛСАН:

“ХААН СОЁМБО АУДИТ” ХХК-НИЙ АУДИТОР

Огноо: 2025-02-20

Р.МЯДАГМАА